

Үндэсний аюулгүй байдалд хуурамч мэдээний үзүүлэх нөлөөлөл

Тогмидын Сүхбаатар

Доктор (Ph.D), шинжээч, sukhbaatar@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

XXI зуунд мэдээлэл, цахим орчин улс орны дотоод, гадаад орчны хөгжлийн гол хүчин зүйл болж байна. Дижитал шилжилт, интернэтийн нэвтрэлт нь нэг талаас ардчилал, мэдээллийн эрх чөлөөг тэлж буй бол нөгөө талаас үндэсний аюулгүй байдалд шинэ төрлийн сорилт учруулж байна. Тэдгээрийн дотор “fake news” буюу хуурамч мэдээ хамгийн түгээмэл, хамгийн хортой үзэгдлийн нэг болжээ.

Түлхүүр үг: Монгол, технологи, социал сүлжээ, олны танил

Нэг. Хуурамч мэдээний тухай ойлголт

Мэдээллийн технологи, социал сүлжээ хурдацтай хөгжихийн хэрээр сүүлийн жилүүдэд мэдээ түгээх хялбар болсон ч үүний зэрэгцээ хуурамч мэдээ (fake news) гэх үзэгдэл дэлхий даяар түгшүүрийн хэмжээнд хүрээд байна. Хуурамч мэдээ нь иргэдийн үнэн зөв мэдээлэл авах эрхийг зөрчихөөс гадна, нийгмийн хагарал, үймээн самуунд хүргэх, нийгмийн итгэлцлийг сулруулах аюултай, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдэл юм.

Хуурамч мэдээ буюу “Fake news” гэж бусдыг төөрөгдүүлэх зорилгоор санаатайгаар бүтээсэн, боловсруулсан хуурамч мэдээ, зураг, видеог хэлдэг. Мөн үнэн зөв мэдээг мушгин, гуйвуулж, буруу мэтээр ойлгуулах нь хуурамч мэдээний төрөлд багтдаг. Иймд мэдээний үнэн бодит эсэхийг нягталж, хуурамч мэдээг ялгаж, таньж сурах нь хамгийн чухал. Хуурамч мэдээ ихэвчлэн олон нийтийг төөрөгдүүлэх, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх, улс төрийн ашиг хонжоо олох зорилготой байдаг.

Хуурамч мэдээ (Fake news) гэх ойлголтыг олон улсын судалгаанд янз бүрээр тодорхойлдог. “Information disorder” хэмээх хүрээнд мэдээллийн гурван төрөлт эмх замбараагүй байдлыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Mis-information – санаатай бус Хуурамч мэдээ.
- Dis-information – санаатайгаар тараасан Хуурамч мэдээ.
- Mal-information – үнэн боловч хор хөнөөлтэйгөөр ашигласан мэдээлэл (Report & Derakhshan, Hossein, 2017)

“Fake news” нь эдгээрийн дундаас дезинформацитай хамгийн ойр бөгөөд улс төрийн зорилгоор ашигладаг, олон нийтийн санаа бодлыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа болж хувирч байдаг (Benkler, Faris, Robert, & Roberts, Hal, 2018).

Хуурамч мэдээ тараагчдын гол зорилго нь тухайн нөхцөл байдал, зорилтот бүлгээс шалтгаалж янз бүр байж болох ч, нийтлэг зорилго нь дараах байдалтай байна. Үүнд:

Нийгмийн сэтгэлзүйд нөлөөлөх. Иргэдийг төөрөгдүүлэх, бухимдуулах, айдаст автуулах гэх мэт. Жишээлбэл: Вирус, вакцин, уран, шатахууны хомсдолын талаар хэт дэвэргэж бичсэн мэдээ зэрэг болно.

Гаднын болон дотоодын улс төрийн ашиг сонирхол. Сонгуулийн үр дүнг өөрчлөх, өрсөлдөгч нам, улс төрчийн нэр хүндийг гутаах, жагсаал цуглаан өдөөх, стратегийн бүтээн байгуулалтыг гацаах гэх мэт.


Санхүүгийн ашиг олох. Хандалт авах замаар сурталчилгааны орлого олох, дагагчаа өсгөх. Хуурамч, баталгаагүй бүтээгдэхүүн, үйлчилгээ сурталчлах. Scam буюу залилан, луйвар хийх (жишээ нь: буруу эм, “Илүүдэл жингээ хасах ийм амархан”, “Хүний дархлааг дэмжиж, залуужуулна”, “Хүний биед ямар ч хор нөлөөгүй, эрүүл мэндийн бүтээгдэхүүн хямд зарна”, “ашигтай” хөрөнгө оруулалт гэх мэт).

Хувийн өшөө хонзон авах, нэр хүнд унагах. Хувь хүн, байгууллагын эсрэг хуурамч мэдээ тараах. Нэр төрд халдах, тулган шаардах.

Үзэл суртал, нийгмийн хуваагдал үүсгэх. Тухайн орны ард түмний дунд зөрчил, хагарал бий болгох. Гадаадын нөлөө бүхий бүлэглэлүүдийн пропаганда явагдах. Гаднын аль нэг улс орны эрх ашгийг гол болгох.

Хуурамч мэдээг иргэдийн ихэнх нь ашигладаг олон нийтийн сүлжээн дээр явуулдаг. Монгол Улсад 2025 оны байдлаар фейсбүүкийг хэрэглэгч нь нийт хүн амын 88.7 хувийг эзэлж байна. Энэ нь хүн амын ихэнх хувь нь нийгмийн сүлжээг өдөр тутмын мэдээллийн гол эх сурвалж болгосон гэсэн үг (NapoleonCat, 2025). **Яагаад Фейсбүүкт хуурамч мэдээ их байдаг вэ?**

1. Хүн амын олонх нь ашигладаг платформоор хуурамч мэдээ түгээх. Өнөөгийн байдлаар Монгол Улсад давхардсан тоогоор 3012800 фейсбүүк хэрэглэгч байгаагийн 53.2 хувь нь эмэгтэйчүүд, 46,8 хувь нь эрэгтэйчүүд байна. Үүнээс 28.3 хувь нь 18-24 насны залуус буюу хамгийн олон 851700 хүнтэй хэрэглэгчийн бүлэг болж байна (Зураг 1).

Зураг 1. Монгол Улс дахь фэйсбүүк хэрэглэгчид

Эх сурвалж: Social media users in Mongolia the last month of 2025. <https://napoleoncat.com/stats/social-media-users-in-mongolia/2025/>

2. Хяналт сул-Шуурхай шалгах механизм хязгаарлагдмал.

3. Алгоритм нь анхаарал татсан контент илүү түгээдэг -Цочирдмоор, сэтгэл хөдлөл өдөөдөг зүйлс илүү тархдаг.

4. Fact-check (үнэн бодит шалгах) мэдээлэл хомс. Сонгуулийн үеэр өрсөлдөгчийн талаар үндэслэлгүй мэдээ тараах. Вирус, өвчин эмгэгтэй холбоотой буруу мэдээ, түгээх, хуурамч зураг, эвлүүлэг видеог их хэмжээгээр ашигладаг.

Хуурамч мэдээг түгээхдээ мэргэжлийн мэт гарчиг, зураг, мэдээний бүтцийг ашиглаж, мэдээний хэлбэртэй сайт дээр байршуулдаг бөгөөд олон хандалттай платформууд, сошиал хаягуудыг ашигладаг байна. Мөн хуурамч мэдээ түгээхэд хамгийн их голлох үүрэгтэй оролцогчид бол “influencer” буюу нөлөөлөгчид юм. Тэд ихэвчлэн бизнес, соёл урлаг, спортын гээд бүхий л салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, дагагч олонтой. Тиймээс хуурамч мэдээг түгээх гол эх үүсвэр болдог. Учир нь хүмүүс өөрийн хүндэлдэг, дагадаг хүний үг, үйлдэлд итгэж, тэдэнд найддаг тул нөлөөлөгчид итгүүлэх арга барилыг ашигладаг. Мөн тэд ихэвчлэн мэргэжлийн бус, нотлогдоогүй зөвлөгөө өгч дутуу дулимаг мэдээлэлд тулгуурлан хуурамч мэдээ түгээх нь элбэг.

Хуурамч мэдээ томоохон зах зээлтэй орнуудад бизнесийн өрсөлдөөнд чиглэдэг бол Монголд ихэвчлэн улс төрийн дайралтын хэрэгсэл болдог. Учир нь манай эдийн засаг, хөрөнгийн зах зээлд нэг мэдээ гараад л хувьцааны үнэ нь унаж, индексүүд улайрах идэвхтэй зах зээл биш. Харин уул уурхайн төслүүдэд нэлээн том цохилт өгч, хохирол учруулсан хэрэг олон бий. Хуурамч мэдээ дэлхийн эдийн засагт жил бүр 78 тэрбум ам.долларын хохирол (Nasrin, S., 2021) учруулдаг гэсэн тооцоо бий.

Хуурамч мэдээний хамгийн оргил үе нь КОВИД-19 цар тахлын үед тохиож байсан. КОВИД-19 цар тахал эхэлсэн цагаас үүнтэй холбоотой хуурамч мэдээ

олширч, зөвхөн хувь хүмүүст төдийгүй нийгэмд бүхэлд нь заналхийлж эхэлсэн. Тухайлбал: Цар тахлын үед “Хүний хамарт чип суулгадаг”, “Вакцин хүний ДНХ-ийг өөрчилнө”, “Эмийн ургамлаар COVID-19 эмчилнэ”, “Орос вакцин сайн” гэх зэрэг хуурамч мэдээ өргөн тархаж, олон нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн (Mongolia, 2022).

Цахим орчин дахь хуурамч мэдээг шалгаж, 39 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлах, 590 гаруй хүн, хуулийн этгээдийг 200 гаруй сая төгрөгөөр торгох арга хэмжээ авчээ (Mongolia, Media Council of, 2022).

Зарим нь мөнгө олохын тулд байсан бол нөгөө хэсэг нь улс төрийн давуу байдал олж авах, өөртөө итгэх итгэлийг бууруулах, буруутган зэмлэх, хүмүүсийг туйлшруулах, цар тахлын эсрэг хариу үйлдлийг сулруулах зэрэг сэдэл агуулж байсан. Нөгөөтээгүүр хувь хүн, зохион байгуулалттай бүлэг, зарим хэвлэл албан ёсны сувгууд ч санаатай болон санамсаргүйгээр хуурамч мэдээ түгээж эхэлсэн байдаг.

Цар тахлын үед “DISINFODEMIC”-н үндсэн дөрвөн төрөл илэрсэн. Үүнд:

1. **Сэтгэл эмзэглүүлсэн өгүүлэмж, бичвэр.** Хувийн үзэл бодол, хуурамч эсвэл бүрэн бус мэдээг үнэний зах зухтай хольсон хуурамч нотолгоо бүхий өгүүлэмж бичвэр. Дээрх төрлийн мэдээг дэлгэц дээрээс шууд харах боломжгүй, хаалттай мессеж, аппликейшнээс олж мэдэхэд хэцүү.
2. **Зохиомол цахим хуудас ба байгууллага.** Үүнд хуурамч эх сурвалж, мушгин гуйвуулсан мэдээ, Засгийн газар эсвэл компанийн хуурамч сайтууд, мөн харахад итгэл үнэмшил төрүүлэхүйц мэдээний төрлийг нийтэлж буй сайтууд багтана. Жишээ нь: КОВИД-19-ийн талаар батлагдаагүй хуурамч тохиолдлуудыг мэдээлэх.
3. **Зохиомол, хам сэдэвтэй холбогдолгүй дүрс, дүрс бичлэг.** Эдгээр нь ерөнхийдөө төөрөгдөл, итгэлгүй байдал эсвэл хүчтэй сэтгэл хөдлөлийг өдөөхийн тулд бүтээсэн пост, reel (нян мэт амархан тардаг богино бичвэр, зураг) эсвэл хуурамч, зохиомол түүхүүд байдаг.
4. **Хуурамч мэдээг найруулан тавих.** Эдгээр нь цахим орчинд маргаан үүсгэх, үндсэрхэг үзэл, геополитикийн асуудлыг дэвэргэх, хувийн эрүүл мэндийн мэдээллийг хууль бусаар цуглуулах, “phishing” хийх (“Загасчлах” буюу нууц үг, зээлийн картын дугаар зэрэг хувийн мэдээллээ илчлэхийг өдөөх зорилготой үйл ажиллагаа); спам болон хуурамч эмчилгээний талаарх зар сурталчилгаанаас мөнгө олох зэрэг багтана. Эдгээр нь мөн хуурамч мэдээ түгээх зохион байгуулалттай ажлын нэг хэсэг болох бот, троллуудаар дайралт хийлгэх, зохиомлоор хандалт нэмэгдүүлэх аргууд байж болно (Pozetti, J.; Boncheva, K., 2022).
5. **Хуурамч мэдээ идэвхэждэг дараагийн цикл бол сонгууль юм.** УИХ-ын 2020, 2024 оны сонгуулийн үеэр зохион байгуулалттай тролл групп, хуурамч мэдээний кампанит ажлууд идэвхтэй өрнөсөн. Хөлсний тролл буюу

“хиамчид”-ийг тодорхой санхүүжилттэй бүлэг хүмүүс удирдан, сэтгэгдэл бичигчдэд хэнийг онилж хэрхэн дайрах талаар зааварчилгаа өгч, нэгийг нь тагнуул, нөгөөг нь хулгайч, хужаа, хууран мэхлэгчээр “цоллон” дайрах байдлаар үйл ажиллагаагаа явуулсан. Сонгогчид үүнд ихэд автан санал өгөх дээрээ хүртэл эргэлзэх болсон. Олон улсын ажиглагчид хэвлэлийн хараат бус байдал хангалтгүй, цахим сурталчилгаа хязгаарлагдмал байсан нь дезинформацийн орон зайг бий болгож болзошгүйг онцолсон. Энэ нь шууд илрээгүй ч, сонгогчдын итгэлд сүүдэр унагаж, сонгуулийн шударга байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөл болсон гэж үзэж болно.

Хоёр. Үндэсний аюулгүй байдалд “Fake News”-ийн үзүүлэх нөлөөлөл

Хуурамч мэдээ (Fake News) нь үндэсний аюулгүй байдлын уламжлалт ойлголтыг шинэ чиглэлд өргөжүүлэх хүчин зүйл болж байна. Тэр дундаа мэдээллийн аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдал, улс төрийн легитимтэй байдал зэрэг суурь ойлголтод ноцтой эрсдэл дагуулдаг юм. Хуурамч мэдээ нь гаднын улс, бүлэглэлүүдийн нөлөөллийн зэвсэг болж, дотоод эв нэгдлийг ганхуулах, улс төрийн тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй. Баталгаагүй мэдээ олон нийтэд давамгайлах үед үндэсний үнэт зүйл, соёлын нэгтгэх хүч сулран, хүмүүсийн нэгдмэл ухамсар алдагдах аюултай.

1. Улс төрд үзүүлэх нөлөө. Хуурамч мэдээ Монголын улс төрийн орчинд хүчтэй, олон талын сөрөг нөлөө үзүүлж байна. Ардчилал хөгжсөн 35 гаруй жилийн туршид Монгол Улс мэдээллийн ил тод байдал, үзэл бодлын эрх чөлөөг өргөжүүлж чадсан боловч энэ нь нөгөө талаас хуурамч мэдээ, дезинформацийн хурдацтай тархах нөхцөлийг бүрдүүлжээ.

Юуны өмнө хуурамч мэдээ нь сонгуулийн үеэр хамгийн их эрсдэл дагуулсан. Тухайлбал, нэр дэвшигчдийн талаарх баримтад үндэслээгүй мэдээ, зориудын хар “пи ар”-ийг өрсөлдөөний гол зэвсэг болон ашиглагддаг. Энэ нь сонгогчдын үнэн зөв мэдээнд суурилсан сонголтыг хязгаарлаж, сонгуулийн үр дүнгийн шударга байдлыг эргэлзээтэй болгосон. УИХ-ын 2020 болон 2024 оны сонгуулийн үед цахим орчинд өргөн хүрээтэй тарсан гүтгэлэг, хуурамч мэдээ олон нийтийн санаа бодолд хүчтэй нөлөөлж, сонгуулийн үйл явцыг будилаантуулах оролдлого гарч байсныг жишээ болгон дурдаж болно.

Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт хуурамч мэдээ тараах”-ыг хориглосон байдаг. Хуулийн энэ заалтыг сонгуулийн сурталчилгааны үеэр зөрчих нь түгээмэл байв. Тухайлбал: Сонгогчдыг санаатайгаар төөрөгдүүлэх зорилготой хуурамч мэдээ, баримт мэтээр түгээсэн хувийн үзэл бодол болон далд сурталчилгаа нийлээд 2020 оны ИТХ-ын сонгуулийн үеэр 29 хувь, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр 21 хувьд хүрч байв (Хүрээлэн, USAID, & IRI, 2021).

Мөн хуурамч мэдээ нь улс төрийн намуудын нэр хүндийг унагаах, институцийн эсрэг үл итгэлцлийг нэмэгдүүлэхэд ашиглагдаж байна. Жишээлбэл: Засгийн газар, УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой хуурамч мэдээ түгэх үед иргэдийн дунд төрд итгэх итгэл эрс буурдаг. Үүний улмаас төрийн шийдвэр гаргах чадвар сулрах, бодлогын хэрэгжилт саарах, улс төрийн тогтворгүй байдлыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Улс төрийн үзэл бодлын ялгааг зориудаар хурцатгасан хуурамч мэдээ нь олон нийтийг талцуулж, нийгмийн эв нэгдлийг сулруулдаг талтай. Энэ нь зөвхөн сонгуулийн үеийн өрсөлдөөнд хязгаарлагдахгүй урт хугацаандаа улс төрийн соёл төлөвшихөд саад болдог. Иймд хуурамч мэдээ Монголын улс төрийн тогтолцоонд сонгуулийн шударга байдал, төрийн институцийн нэр хүнд, иргэдийн итгэлцэл, нийгмийн эв нэгдэл, гадаад нэр хүнд зэрэг олон талт ноцтой сорилт учруулж байна. Үүнийг бууруулахын тулд төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн хариуцлагыг чангатгах, олон нийттэй ажиллах чадвар буюу медиа боловсролыг хөгжүүлэх шаардлагатай юм.

Иймээс Монгол Улсад мэдээллийн боловсролыг төлөвшүүлэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх бодлого нь хуурамч мэдээний сөрөг нөлөөг бууруулахад чухал ач холбогдолтой болно. Хуурамч мэдээтэй үр дүнтэй тэмцэх нь зөвхөн улс төрийн тогтвортой байдлыг хамгаалахаас гадна ардчиллыг бататгах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх чухал алхам болох юм.

2. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл. Хуурамч мэдээ нь нийгмийн бүлгүүдийн хооронд үл ойлголцол бий болгож, сошиал орчинд үзэн ядалтыг өдөөдөг байна. Иргэдийн дунд бодит байдалд үл итгэх, төр, байгууллага, хэвлэлд эргэлзэх байдал нэмэгддэг. Тэд төрийн зүгээс гаргасан бүхий л мэдээнд үл итгэж, нөлөөлөгч олны танил хүмүүст итгэж эхэлдэг талтай. Ингэснээр төрийн бодлого шийдвэрт итгэдэг болон үл итгэгч нар гэсэн хуваагдал үүсдэг байна. Үр дүнд нь иргэдийн дунд туйлшрал, маргаан ширүүсэж, эрүүл хэлэлцүүлгийн орчин алдагдана.

Нийгмийн эв нэгдлийн хамгийн чухал хүчин зүйл бол харилцан итгэлцэл юм. “Fake news” энэ итгэлцлийг нийгмийн бүх түвшинд доройтуулдаг. Төрдөө итгэх итгэл ч алга болдог. Хуурамч мэдээ, ялангуяа гамшиг, цар тахал, улс төрийн тогтворгүй байдлын тухай бол иргэдийн дунд хүчтэй айдас, түгшүүр үүсгэдэг байна. Хэт их мэдээлэл, түүн доторх хуурамч мэдээний урсгал нь хүний танин мэдэхүйн чадавхыг алдагдуулж, бухимдал, сэтгэлийн дарамт үүсгэдэг. Хуурамч мэдээнд удаа дараа өртсөнөөр хүний үнэн худлыг ялгах чадвар буурч, сэтгэлгээний гажуудал бий болдог. Энэ нь “confirmation bias” буюу зөвхөн өөрийн үзэл бодолд нийцсэн мэдээг хүлээн авах хандлагыг улам дэвэргэдэг ажээ. “Fake News” ихэвчлэн нэг хэсгийг нь магтаж, нөгөөг нь буруутгах агуулгатай байдаг тул олон нийтийг талцуулах, туйлшруулах үр дагавар үзүүлнэ.

3. Эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл. Хуурамч мэдээ (fake news) нь Монгол Улсын эдийн засагт богино болон урт хугацааны ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ үзэгдэл нь зах зээлийн хэлбэлзэл, хөрөнгө оруулалтын итгэл, төрийн бодлогын хэрэгжилт, олон улсын нэр хүнд зэрэгт шууд болон дам нөлөө үзүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулах аюултай.

Юуны өмнө хуурамч мэдээ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулдаг. Монгол Улс уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц зэрэг стратегийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай тул эдгээр салбарын талаар үндэслэлгүй, зориуд тараасан ташаа мэдээ гарвал хөрөнгө оруулалтын орчинд эргэлзээ төрж, шинэ төсөл хэрэгжих явц саардаг. Үүний улмаас хөрөнгө татах боломж хумигдаж, эдийн засгийн өсөлт саарах нөхцөл бүрдэнэ.

Хуурамч мэдээ нь санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсгэдэг. Компанийн нэр хүндийг гутаасан, эсвэл үйл ажиллагааг нь буруугаар ойлгуулах зорилготой мэдээ хувьцааны үнийн хэлбэлзэл, хөрөнгө оруулагчдын итгэл алдалт, банк санхүүгийн тогтворгүй байдалд хүргэдэг. Монголынх шиг жижиг, эмзэг зах зээлд ийм мэдээллийн нөлөө илүү хурцаар биш ч гэсэн аажимдаа урт хугацаанд илэрч, зах зээлийн тогтвортой байдлыг ганхуулах аюултай. Мөн бизнесийн шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлдөг. Зарим тохиолдолд өрсөлдөгч талууд хоорондоо зориуд худал мэдээ тарааж, хэрэглэгчдийн итгэлийг алдуулах замаар бизнесийн орчныг гажуудуулдаг. Үүний үр дүнд жижиг, дунд аж ахуйн нэгжүүд дампуурах, ажлын байр буурах, хэрэглэгчдийн худалдан авах чадвар болон зах зээлийн идэвхжил сулрах эрсдэлийг үүсгэнэ. Нөгөө талаар хуурамч мэдээ нь төрийн эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд хүндрэл учруулдаг. Татварын шинэчлэл, уул уурхайн хууль эрх зүйн орчин, гадаад худалдааны бодлого зэрэг асуудлаар ташаа мэдээ түгэхэд олон нийтийн дэмжлэг буурч, бодлогын хэрэгжилт удааширдаг. Энэ нь төрийн шийдвэрийг тогтворгүй, итгэл султай харагдуулах бөгөөд эдийн засгийн реформын үйл явцыг тасалдуулах аюултай.

Хуурамч мэдээ нь олон улсын зах зээлд Монгол Улсын нэр хүндийг алдагдуулах хүчин зүйл болдог. Уул уурхайн нөөц, бүтээгдэхүүний чанар, нийлүүлэлтийн тогтвортой байдлын талаар үндэслэлгүй мэдээ тархвал Монголын экспортын нэр хүнд унаж, худалдааны гэрээ цуцлагдах, төлбөрийн тэнцэл болон валютын ханшид дарамт үүсэх эрсдэлтэй.

Ийнхүү хуурамч мэдээ нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн шударга өрсөлдөөн, төрийн бодлогын хэрэгжилт, олон улсын нэр хүнд зэрэг олон талбарт сөрөг үр дагавар авчирч байна. Иймээс мэдээний үнэн зөв, ил тод байдлыг хангах, баримтад суурилсан мэдээллийн соёлыг төлөвшүүлэх нь эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг баталгаажуулах чухал нөхцөл юм. Төр, бизнес, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилсан “мэдээллийн дархлаа” бүрдүүлж чадвал хуурамч мэдээний эдийн засагт үзүүлэх хор хөнөөлийг бууруулах бүрэн боломжтой.

4. Гадаад харилцаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл. Хуурамч мэдээ нь Монгол Улсын гадаад харилцаа болон гадаад бодлогод олон талын сөрөг нөлөө үзүүлж байдаг. Юуны өмнө улсын нэр хүндэд хүчтэй нөлөөлөх бөгөөд үндэслэлгүй мэдээ тарах нь Монголыг ардчилал султай, авлига өндөртэй, хүний эрхийг үл хүндэлдэг, аюултай орон мэтээр харуулах талтай. Ийм ойлголт гадаадын хэвлэл болон судалгааны байгууллагуудаар дамжин түгэхэд Монголын талаарх бодит бус дүр төрх олон улсад тогтож, зөөлөн хүчний чадавх буурах, улмаар олон улсын хамтын ажиллагааны орон зай хязгаарлагдах эрсдэл бий болдог.

Үүнээс гадна хуурамч мэдээ нь дипломат харилцаанд үл итгэлцэл бий болгож, хөрш болон түнш орнуудтай үүссэн итгэлцлийн орчныг доройтуулах магадлалтай. Хил, байгалийн баялаг, эсвэл гадаад бодлогын байр суурьтай холбоотой хуурамч мэдээ зориуд түгээх нь хоёр улсын харилцааг хурцатгаж, олон улсын хэлэлцээр болон хамтын ажиллагаанд саад болдог. Энэ нь Монголын гадаад бодлогын уян хатан байдал, тэнцвэртэй байр суурийг хамгаалах чадварт сөргөөр нөлөөлнө. Жишээлбэл: “Орос, хятадууд Монголыг эзлэх гэж байна”, “Хятад иргэд олноор суурьших боллоо”, “Монгол Улсын хилийг өөрчилсөн” гэх мэт. Нөгөө талаас хуурамч мэдээний зохион байгуулалттай кампанит ажил нь Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого болон эвсэл холбооны бодлогыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, олон улсын түншүүдийн дунд Монголыг тогтворгүй, нэг улсад хэт хамааралтай улс мэтээр ойлгуулах оролдлого бий болгодог. Энэ нь Монгол Улсын бие даасан, тэнцвэртэй гадаад бодлогын зарчим хэрэгжихэд саад болж, олон улсын хамтын ажиллагаанд эзлэх байр суурийг сулруулахад хүргэнэ. Цаашлаад хуурамч мэдээ нь Монголын олон улсын байгууллагуудад илэрхийлдэг байр суурийг гуйвуулж, уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, энхийг сахиулах зэрэг чухал асуудлаар буруу байр суурьтай мэтээр ойлгуулж болох бөгөөд энэ нь олон улсын дэмжлэгийг сулруулах эрсдэлтэй.

Иймд хуурамч мэдээ нь Монгол Улсын гадаад харилцаа, гадаад бодлогын нэр хүнд, дипломат харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гуравдагч хөршийн бодлогын хэрэгжилтэд урт хугацааны сөрөг үр дагавар үзүүлдэг гэдгийг тодотгох шаардлагатай. Тиймээс Монгол Улс олон улсын хэмжээнд олон нийттэй харилцах дипломат ажиллагаа, баримт нягтлах тогтолцоо, гадаад сурталчилгаа болон стратегийн харилцааны бодлогоор дамжуулан өөрийн байр суурийг хамгаалж, хуурамч мэдээний эсрэг хамгаалалтын механизмаа бэхжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Орчин үеийн мэдээллийн эринд “Хуурамч мэдээ” буюу **“fake news”** нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд улам бүр ноцтой сорилт авчирч байна. Цахим орчин, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиал сүлжээний хурдацтай хөгжил нь үнэн бодит мэдээ, мэдээллийг түгээх боломжийг нэмэгдүүлсэн ч нөгөө талаар Хуурамч мэдээ богино хугацаанд олон нийтийн сэтгэл зүйг гуйвуулж, улс орны тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хуурамч мэдээ улс төрийн салбарт шууд нөлөө үзүүлж, сонгуулийн шударга өрсөлдөөнд саад учруулж, иргэдийн улс төрийн сонголтыг гуйвуулах эрсдэлтэй. Энэ нь төрийн байгууллагын нэр хүндийг сулруулж, ардчиллын үнэт зарчим болох итгэлцлийг доройтуулахад хүргэдэг. Мөн гадаадын мэдээллийн нөлөөлөлтэй хавсарвал Монгол Улсын гадаад бодлого, үндэсний ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх боломжтой.

Нийгмийн түвшинд хуурамч мэдээ нь иргэдийн хооронд үл итгэлцэл, үл ойлголцлыг бий болгож, нийгмийн эв нэгдлийг сарниулдаг. Үнэн ба худлын ялгаа бүдгэрсэн үед олон нийтийн дунд хуваагдал, зөрчилдөөн нэмэгдэж, хамтын үнэт зүйлсийн доройтол үүсгэдэг. Энэ нь улс орны тогтвортой байдал, үндэсний дархлаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг юм.

Эдийн засгийн хувьд хуурамч мэдээ нь бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын итгэлцэлд шууд нөлөөлдөг. Санхүүгийн зах зээлд тараасан хуурамч мэдээ нь ханшийн савлагаа үүсгэж, хөрөнгө оруулагчдыг айлгаж, зах зээлийн тогтвортой байдлыг алдагдуулдаг. Мөн дотоодын компани, бүтээгдэхүүний талаарх гуйвуулсан мэдээ нь зах зээлд өрсөлдөх чадварыг сулруулж, урт хугацааны эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг.

Хуурамч мэдээний гол аюул нь үндэсний эв нэгдэлд чиглэж байна. Монгол Улс шиг хүн амын тоо цөөн, нийгмийн эв нэгдэлд тулгуурлан оршин тогтнож ирсэн оронд хуурамч мэдээ нь хиймэл хуваагдал, үл итгэлцэл бий болгож, үндэсний аюулгүй байдлын суурийг ганхуулж болзошгүй. Иймээс хуурамч мэдээний эсрэг хийх тэмцэл нь зөвхөн техникийн болон хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин боловсрол, мэдээллийн дархлаа, олон нийтийн оролцоонд тулгуурласан цогц арга хэмжээгээр хэрэгжих ёстой. Иргэдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, шуурхай ажиллагааг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх нь урт хугацааны тогтвортой хамгаалалт болно.

Ирээдүйд Монгол Улс мэдээллийн дархлаагаа бэхжүүлж, хуурамч мэдээний сөрөг нөлөөллийг бууруулж чадвал үндэсний аюулгүй байдал, дотоодын тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийн баталгаа улам бүр бэхжиж, ардчиллын чанар, олон улсын нэр хүнд, нийгмийн эв нэгдэл улам баталгаажих боломжтой юм.

Эх сурвалжийн жагсаалт

- Benkler, Y., Faris, Robert, & Roberts, Hal. (2018). *Network propaganda: Manipulation, disinformation, and radicalization in American politics* [Сүлжээний суртал ухуулга: Америкийн улстөр дэх манипуляци, Хуурамч мэдээ ба радикалчлал]. Oxford: Oxford University Press.
- Mongolia, M. C. (2022). *Digital Media Literacy in Mongolia: Survey Report* [Мэдээллийн технологи, медиа боловсролын түвшин Монголд: Судалгааны тайлан]. Ulaanbaatar: Media Council of Mongolia.

Mongolia, Media Council of. (2022). *Digital Media Literacy in Mongolia: Survey Report* [Мэдээллийн технологи, медиа боловсролын түвшин Монголд: Судалгааны тайлан]. Ulaanbaatar: Media Council of Mongolia.

NapoleonCat. (2025). *Social media users in Mongolia: The last month of 2025*. NapoleonCat: <https://napoleoncat.com/stats/social-media-users-in-mongolia/2025/>

Nasrin, S. (2021 оны April 26). *Impact of fake news on the global economy* [Худал мэдээллийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө]. IBTBD: <https://ibtbd.net/impact-of-fake-news-on-the-global-economy/>

Pozetti, J.; Boncheva, K. (2022). *Disinfodemic: Understanding COVID-19-related misinformation in times of digital media* [Дисинфодемик: Ковид-19-тэй холбоотой мэдээллийн цар тахлыг ойлгох хичээл]. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.

Report, C., & Derakhshan, Hossein. (2017). *Information disorder: Toward an interdisciplinary framework for research and policy making* [Мэдээллийн эмх замбараагүй байдал: Судалгаа ба бодлого боловсруулахад зориулсан олон салбарын хандлага]. Strasbourg: Council of Europe.

Wardle, C. &. (2017). *Information Disorder: Toward an Interdisciplinary Framework for Research and Policy Making*. Council of Europe.

Хүрээлэн, Х., USAID, & IRI. (2021). *Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан: Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 2020, Ерөнхийлөгчийн сонгууль 2021* [Media Monitoring Report: Local Representative Elections 2020, Presidential Election 2021]. Улаанбаатар: Хэвлэлийн Хүрээлэн. <https://resource4.sodonsolution.org/irim/file/IRIM%202021%20MGL.pdf>

The Impact of Fake News on National Security

Sukhbaatar Togmid

Doctor (Ph.D), Expert, sukhbaatar@iss.gov.mn
The Institute for Strategic Studies,
National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

In the 21st century, information and the digital space have become key factors in the internal and external development of nations. Digital transformation and the widespread use of the internet, on the one hand, have expanded democracy and freedom of information, while on the other hand, they have posed new types of challenges to national security. Among these challenges, “fake news” has emerged as one of the most widespread and most harmful phenomena.

Keywords: Mongolia, Social media, Internet, Influencer, Hybrid warfare

Received: September 5, 2025 | Accepted: September 12, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025
<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.